



7, 8 дугаар сар 2017 он


СУУРЬ БҮТЭЦ ДЭХ ХӨДӨЛГӨӨНИЙ ЗУРМАГИЙН ГҮЙЦЭТГЭЛД ШИНЖИЛГЭЭ ХИЙЛЭЭ

Галт тэрэгний зурмаг зохицуулалтын журмын 6.1-д заасны дагуу хөдөлгөөний нэгдсэн зурмагийн гүйцэтгэлийг сайжруулах, суурь бүтцийн тээх, нэвтрүүлэх чадвар, суурь бүтэц эзэмшигчийн хөдлөх бүрэлдэхүүний ашиглалтад хяналт тавих зорилгоор суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагийн гүйцэтгэлд шинжилгээ хийж, ажлын үр дүнг ЗТХЯ-нд танилцууллаа. Төмөр замын тээврийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.4-т заасан галт тэрэгний хөдөлгөөний удирдлагатай холбоотой санал дүгнэлт гаргаж шийдвэрлүүлэх бүрэн эрхийн хүрээнд суурь бүтцийн галт тэрэгний хөдөлгөөний 2016-2017 оны өвлийн зурмагийн гүйцэтгэлд шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээний талаар санал зөвлөмж боловсруулж төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад танилцуулж хөдөлгөөний нэгдсэн зурмагийн гүйцэтгэлийг сайжруулахад энэхүү шинжилгээний зорилго чиглэгдэж байгаа юм.

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН ДҮРЭМ, ЖУРМЫГ ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛЬД НИЙЦҮҮЛЭН ШИНЭЧЛЭН БАТЛУУЛАВ

Төмөр замын тээврийн тухай хуульд заасан дүрэм, журмыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн шинэчлэн боловсруулж, батлуулах ажлыг зохион байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 16 дугаар тушаалаар ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ-ын дарга Б.Артур, “ГТХЗНТ” УТҮГ-ын захирал Т.Ариунбаатар нарт даалгасантай холбогдуулан Төмөр замын тээврийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.9, 25 дугаар зүйлийн 25.4, 26 дугаар зүйлийн 26.1, 28 дугаар зүйлийн 28.1-д заасан Суурь бүтэц ашиглуулах журам, Хатуу тооцоот багаж, хэрэгслийг ашиглах болон хүлээлцэх журам, Аюултай байгууламж байрлуулах зай, огтлолцлын болон байршлын нөхцөлийг тодорхойлох журам, Төмөр замын гарам ашиглах журмыг шинэчлэн боловсруулж, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017.07.06-ны өдрийн 140, 2017.07.16-ны өдрийн 141, 2017.07.28-ны өдрийн 146, 2017.08.02-ны өдрийн 148 дугаар тушаалаар тус тус батлууллаа.

Төмөр замын тээврийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т заасан Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтөлөх, хүлээлцэх журмын төсөлд Захиргааны ерөнхий хуулийн 62.1-д заасны дагуу санал авах зорилгоор төвийн цахим хуудсанд байршуулж, журмын төсөлд “МТЗ” ТӨХК, “УБТЗ” ХНН, “БТЕГ” ХХК-иас, ЗТХЯ-ны ХШУДАГ-аас ирүүлсэн саналыг нэгтгэж, ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэв. Ажлын хэсгийн гишүүдээс гарсан саналыг журмын төсөлд тусгаж, төслийг ажлын хэсгийн болон ЗТХЯ, “УБТЗ” ХНН, “БТЕГ” ХХК-ийн вагон, вагоны аж ахуйн инженер, албан тушаалтнуудад танилцуулж, журмын төсөл, тэдгээрийг хэлэлцсэн ажлын хэсгийн хурлын тэмдэглэлүүд, саналын хүснэгт зэрэг баримт бичгийг “УБТЗ” ХНН, “МТЗ” ТӨХК, ЗТХЯ-ны 11 албан тушаалтанд танилцуулж гарын үсэг авч эцсийн байдлаар албажуулан ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ-ын ахлах мэргэжилтэн, ажлын хэсгийн ахлагч Т.Мөнхцэцэгт батлуулахаар хүлээлгэн өгөөд байна.





7, 8 дугаар сар 2017 он

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ҮНЭЛГЭЭ ХИЙЛЭЭ



Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 115 дугаар тушаалаар байгуулагдсан Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсэг Хууль тогтоомжийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ыг үндэслэн Төмөр замын тээврийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, салбарын байгууллагуудын санал хүсэлтийг сонсож, хэлэлцүүлэг зохион байгуулав.

МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТЭРЧ БУЙ ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮНИЙ БҮРТГЭЛ ХӨТЛӨХ, ХҮЛЭЭЛЦЭХ ЖУРМЫН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАВ

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 16 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг хуралдаж, Төмөр замын тээврийн тухай хуулийн 15.1.12-т заасан Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх журмын төслийн хэлэлцүүлгийг зохион байгуулав. Ажлын хэсгийн гишүүдээс гарсан саналыг журмын төсөлд тусгаж, төслийг “УБТЗ” ХНН, “МТЗ” ТӨХК, “БТЕГ” ХХК-д тус тус хүргүүлсэн.

ЭРҮҮГИЙН ХЭРЭГТ ШИНЖЭЭЧЭЭР АЖИЛЛАА

ЦЕГ-ын Төмөр зам дахь цагдаагийн газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасгийн ахлах мөрдөн байцаагч, цагдаагийн ахмад Г.Мөнхсайханы 2017 оны 07 дугаар сарын 21 болон 2017 оны 08 дугаар сарын 11-ны өдрийн “Шинжээч томилж, шинжилгээ хийлгэх тухай” тогтоолыг үндэслэн 2016.12.29-ны өдөр Чойр хэсэглэлийн харьяа Шивээ-Овоо өртөөний 1-р зам дээр гарсан осол болон 2017.01.09-ны өдөр УБТЗ-ын Зам засварын машинт станцын аж ахуйн хашаанд гарсан ослын 201724000035; 201724000045 дугаартай хавтаст хэрэгт цугларсан нотлох баримтын хүрээнд шинжилгээ хийж дүгнэлт гаргасан.

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАН АЖИЛЛАЖ БАЙНА

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7, 8 дугаар зүйлд заасан үйл ажиллагааны болон хүний нөөцийн ил тод байдал, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4 дэх хэсэг, Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журамд заасан мэдээллийг rtcc.mrtd.gov.mn, info.shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулж мэдээлж байна. Тухайлбал: Шилэн дансны хүрээнд тухай бүр оруулах 8 төрлийн мэдээг 64 удаа, сар бүр оруулах 3 мэдээг 24 удаа, улирал тутамд оруулах 1 мэдээг 2 удаа, хагас жилээр оруулах 4 мэдээг 1 удаа, бүтэн жилээр оруулах 5 мэдээг 1 удаа нийт 21 мэдээллийг 92 удаа бэлтгэн оруулсан. Мөн хүний нөөцийн ил тод байдлыг хангах хүрээнд төвийн хүний нөөцийг бүрдүүлэхдээ сул орон тооны ажилтан шалгаруулж авах мэдээллийг Ган зам сонин болон rtcc.mrtd.gov.mn цахим хуудсанд байршуулж ажил горилогчдыг судлан, тодорхой үе шаттайгаар сонгон шалгаруулалтыг хийн ажиллаж байна.



7, 8 дугаар сар 2017 он

ОЛОН УЛСЫН ТӨМӨР ЗАМЫН ХӨДӨЛГӨӨН УДИРДЛАГЫН ТӨВҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ СУДАЛЛАА

БНХАУ, ОХУ, ХБНГУ, Япон улсын галт тэрэгний хөдөлгөөн зохицуулах нэгдсэн төвийн үйл ажиллагаа, тэдгээрийн хоорондын харьцуулсан судалгааг хийлээ. Судалгааны үр дүнд ГТХЗНТ-ийн үйл ажиллагаа, хамрах хүрээ, чиг үүрэг, техник технологи, барилгын зураг төсөл, тоног төхөөрөмж суурилуулахад тавигдах ерөнхий шаардлага, хөрөнгө оруулалт зэргийг тодорхойлоход тус дэм болох төдийгүй олон улсын галт тэрэгний хөдөлгөөн удирдлагын төвүүдийн үйл ажиллагаа, техник технологиос өөрийн оронд нутагшуулахад тус судалгаа чухал нөлөө үзүүлнэ.

Харьцуулсан дүн шинжилгээ

Олон улсын галт тэрэгний хөдөлгөөн удирдлагын төвийн үйл ажиллагаа

ОХУ

- Хяналтын төв нь Москва хотод байрладаг.
- Гүйцэтгэсэн компани: Siemens компания
- KLUB системийг ашигладаг
- ALSN системийг муруудад голчлон ашигладаг систем юм

БНХАУ

- Хяналтын төв нь Вольфен, Швабей, Гундесхайм хотод байрладаг.
- Гүйцэтгэсэн компани: Сингапурын ST Engineering Ltd
- 2006 ажилтан, 600 ирчим шинжилгээний ажилтан, 278 судалгаачтай.
- СТСБ-ийг ашигладаг бөгөөд ETCS-ийн стандартын дагуу боловсруулсан.

ХБНГУ

- Дэлхийн төмөр замын дэдирдлэгийн төвийн төв нь ХБНГУ-нд байрладаг.
- Гүйцэтгэсэн компани: Siemens компания
- Үйл ажиллагааны 7 төвтэй ба 2000-нөөс илүүтэй хяналдаг
- Девелопсын диспетчер ба хяналт цахилгаан интерлокалийн төвийн үйл ажиллагааг төвлөрсүүлсэн

Япон улс

- Хяналтын төв нь Токио, Осака хотод байрладаг
- Гүйцэтгэсэн компани: JR central компания
- 2006 ажилтан, 600 ирчим шинжилгээний ажилтан, 278 судалгаачтай
- ATC болон ATOS-ийг ашигладаг

Харьцуулсан дүн шинжилгээ

Олон улсын галт тэрэгний хөдөлгөөн удирдлагын төвийн үйл ажиллагаа

ийн Удирдлага ба Менежментийн Системийг хамрах хүрвэгээр нь галт тэрэгний төрөл, бүрэлдэхүүн хэсэг, илгээл аээр үйлдсэн сегментчилсэн. Галт тэрэгний төрөвөөр нь зах зээлийн мөхөөр ба өндөр хурдны галт тэрэг дий төрөн нэгж, дизель олон төрөн нэгж болгон хуваадаг бол бүрэлдэхүүний дагуу зах зээлийг компьютерийн эгж, модуль ордуу/гаранттай төхөөрөмж, хөдөлгөөн харилцаа хөдөлгөөн галт, хүн машин интерфэйс гэж дин хэрэгтэй шинжлэл нь галт тэрэгний нэгдсэн эвэлт, тогтмол хяналт, хяналтын урлага буюу хяналт гэж эн хурдтай жогтой, эрчим хүчний хэмжээтэй төмөр замын эрэлт хэрэгцээг нэмэгдүүлж, транзит төврийн төв тухай эрэлт хэрэгцээг нэмэгдүүлэх нь галт тэрэгний хяналт, менежментийн системийг жөлөхдөг гол хүчин

Өндөр хурдын төмөр замыг дэлхийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэх нь ирэх жилүүдэд зах зээлд хэд хэдэн лөмхийг олгоно.

ийн галт тэрэгний хяналт ба менежментийн систем

Зах зээлийн зах зээл хувь бүсээр

Эх сурвалж: Variant market research


Гол үйлдэрлэгчид

- > Bombardier Inc
- > Toshiba Corporation
- > Mitsubishi Electric Corporation
- > Alstom SA
- > Siemens AG
- > Hitachi Ltd
- > EKE Electronics
- > Skunkin Rail
- > Thales Group

САЛБАРЫН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН БҮРДҮҮЛЭН АЖИЛЛАЖ БАЙНА

Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох, хугацаа сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох чиг үүрэг бүхий гэрчилгээжүүлэлтийн мэдээллийн сан бүрдүүлэх, шаардлагатай боловсон хүчин болон бусад нөхцөл шаардлагын давхцалыг бүртгэх, шалгах програм хангамжийг төвийн үйл ажиллагаанд ашиглахаар боловсруулан ажиллаа. Тус програм хангамжийн өгөгдлийн санг MySQL програм дээр зохион байгуулснаар мэдээллийн сан архивлах, бусад програм хангамж руу шилжүүлэн ажиллахад бүрэн боломжтой ба үнэ төлбөргүй програм хангамж юм. Програмын эх кодыг вэб хандалттай PHP програм дээр тулгуурлан боловсруулсан.

ТЭЭВЭРЛЭЛИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ



Зорчигч тээвэрлэлт долоодугаар сард 241.1 мян.зор тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 6.8%-аар буурсан, ачаа тээвэрлэлт долоодугаар сард 1903.6 мян.тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 19.5%-аар өссөн үзүүлэлттэй байна.



Дамжин өнгөрсөн ачаа 2017 оны долоодугаар сарыг өмнөх оныхтой харьцуулбал 37.13%-аар, 2017 оны эхний долоон сарыг өмнөх оны мөн үетэй харьцуулбал 18.94%-аар өссөн байна.



Долоодугаар сард 1268.03 мян.тн ачаа ачиж өмнөх оны мөн үеэс 11.1%-аар, эхний долоон сарын ачилтыг өмнөх оныхтой харьцуулбал 12.3%-аар өссөн үзүүлэлттэй байна.



7, 8 дугаар сар 2017 он

“ХОС ЗАМ” СУРГАЛТЫН ТӨВ “ТӨМӨР ЗАМЫН ЗАМЧИН” МЭРГЭЖЛЭЭР ЭЛСЭЛТ АВЛАА

Төв нь 2017 оны 08 дугаар сараас эхлэн “Төмөр замын замчин” мэргэжлээр нийслэлийн 6 дүүргийн ажилгүй, мэргэжилгүй, цэргээс халагдсан гэх мэт зорилтот бүлгийн иргэдийг богино хугацааны мэргэшүүлэх сургалтад хамруулж мэргэжлийн үнэмлэх олгон мэргэжилтэй ажилтныг бэлтгэхээр зорин ажиллаж байна. Одоогийн байдлаар сургалтад хамрагдахыг хүссэн эхний 25 иргэнийг бүртгэж сургалтыг эхлүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

ТӨВИЙН МЭРГЭЖИЛТНҮҮД БНХАУ-ААС ЗОХИОН БАЙГУУЛЖ БҮЙ СУРГАЛТУУДАД АМЖИЛТТАЙ ХАМРАГДАВ

БНХАУ-ын Худалдааны яам, Олон улсын худалдаа, бизнесийн академиас Сы Чуань мужийн Чэнь Дү хотноо зохион байгуулсан “Төмөр замын инженерчлэлийн удирдлага, барилга байгууламжийн технологи”, “Төмөр замын дохиоллын технологийн ахлах ажилтнуудын сургалт”-д Төвийн мэргэжилтнүүд хамрагдлаа. Энэ удаахын сургалт лекц, семинар, кейс судалгаа, техник, технологитой танилцах, практик дадлага зэрэг төрлөөр явагдсан бөгөөд Төмөр замын барилга, байгууламжийн зохицуулалт, удирдлага, замын доод бүтэц, барилгын технологи, инженерчлэлийг байгалийн гамшгаас хамгаалах, төмөр замын барилга, байгууламж дахь BIM-ын хэрэглээ гэсэн агуулгатай байв. Сургалтад хамрагдсан мэргэжилтнүүд БНХАУ-ын томоохон үйлдвэр, компаниудаар зочилж, мэргэжлийн хүмүүстэй санал солилцож, Хятадын эдийн засаг, хөгжлийн талаар тодорхой ойлголттой болж, хамтран ажиллах боломж бүрдэх юм.



ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН САЛБАРЫН МЭРГЭШСЭН, ЗӨВЛӨХ ИНЖЕНЕРИЙН ЗЭРЭГ АХИУЛАХ, СУНГАХ ЧИГЛЭЛЭЭР ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДАТ ХАМТРАН АЖИЛЛАЖ БАЙНА

Монголын мэргэшсэн зөвлөх инженерүүдийн холбооноос зохион байгуулсан сургалтад хамрагдаж, зөвлөх болон мэргэшсэн инженерийн мэргэжилтэнд тавигдах шаардлага хангасан 37 инженерийн мэргэжлийн зэрэг шинээр олгох, сунгах асуудлыг шийдвэрлүүлэхээр холбогдох шийдвэрийн төслийг хүргүүлээд байна.

“Мэргэшсэн, зөвлөх инженер”-ийн зэрэг шинээр олгох, мэргэжлийн зэрэг сунгах сургалтад хамрагдсан инженерийн мэргэжлийн шалгалтын нэгдсэн дүн болон сэдэв хамгаалалтын дүнг төмөр замын тээврийн салбарын мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж тус хурлаас гарсан шийдвэрийг ЗТХЯ-нд албан бичгээр хүргүүлэн Төрийн нарийн бичгийн даргын тушаалын дагуу мэргэшсэн болон зөвлөх инженерт батламж, гэрчилгээ, тэмдэг олгох ажлыг зохион байгуулан ажиллаж байна.



7, 8 дугаар сар 2017 он

ТӨМӨР ЗАМЧИД ДЭЛГЭР САЙХАН НААДАМЛАЛАА

Монгол Улсад төмөр замын тээвэр үүсч хөгжсөний 79 жил, Төмөр замчдын мэргэжлийн баярын өдөр уламжлал ёсоор жил бүрийн 08 дугаар сарын эхний долоо хоногийн Баасан, Бямба гаригт буюу энэ сарын 05-06-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. Тус өдөр эрхэлсэн ажилдаа идэвх санаачилгатай хандаж, хөдөлмөр бүтээлийн амжилт гарган, хамт олноо ажил үйлсээрээ манлайлсан Төвийн Технологи, мэдээлэл, сургалт, судалгааны хэлтсийн дарга Б.Энхжаргал төрийн дээд шагнал “Алтан гадас одон”, мэргэжилтэн Б.Оюунчимэг “Хүндэт төмөр замчин” цол тэмдгээр тус тус шагнууллаа. Төвийн хамт олны зүгээс эрүүл энх, аз жаргал, амжилт бүтээлийн дээдийг хүсэн ерөөе.

